

БАТЛАВ

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

Г.АНХЖАРГАЛ

Хувилбар А

Анги дэвших шалгалт “Нийгэм” Х анги / сонгох шалгалт/

1. Судалгааны сэдэв сонгох, сэдвээс асуултыг нарийвчлах, судлах загвараа боловсруулах үйл ажиллагаа нь судалгааны аль үе вэ? 1 оноо
 - а. судалгааны эхэн үе
 - б. Судалгааны бэлтгэл үе
 - в. судалгааны дараах үе
 - г. судалгааны дүгнэлтийн үе
2. “ Нийгмийн бодит байдлыг судлах нь хүмүүс хэрхэн харилцдаг, хүмүүсийн үйлдэлд илрэх утга учрыг тэдний нүдээр харж ойлгох явдал. Нийгмийн тухай ерөнхий онол гэж байх боломжгүй ба судлагдсан бодит байдлаас индукцийн аргын дагуу тодорхой түвшний онолыг бүтээх боломжтой” ” гэдэг нь нийгмийг судлах \ социологийн \ аль онол вэ? 2оноо
 - а. Бүтэц чиг үүргийн онол
 - б. Марксизм \ шүүмжлэлт онол
 - в. бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн онол
 - г. эдийн засгийн онол
3. Буд Ангараг Сугар болон бусад гарагууд нь дэлхийг биш нарыг тойрдог гэж Н.Коперник үзсэн.Гэрлэлтээс гадуурх харилцааг харуулсан “Анна Каренина” зохиолыг Л. Толстой бичсэн. Эдгээр хүмүүсийн үзлүүд тухайн үеийн нийгмийн хэм хэмжээнд нийцэхгүй асуудлыг хөндсөн байлаа. Үүнийг өнөөгийн ардчилсан нийгмийн өнцгөөс харвал хэм хэмжээ зөрчсөн үйлдлийн ямар төрөлд хамаарагдах вэ? 2оноо
 - а. Нийгмийн гажуудал буюу девиаци
 - б. Аялдах үйлдэл буюу конформист
 - в.Нийгмийн үүрэг давхцах
 - г.Алдар хүнд
- 4.” Монгол хэлний тухай “ хууль хэзээ батлагдсан бэ? 1оноо
 - а. 2000 он
 - б . 2005 он
 - в . 2015 он
 - г . 2018 он
5. Бүхий л соёлд нийтлэг байдаг шинж чанар, хэм хэмжээ, дүрэм журам, үнэт зүйлсийг юу гэж нэрлэдэг вэ? 1оноо
 - а. Соёлын хэм хэмжээ
 - б . соёлын нийтлэг
 - в. соёлын түгээмэл
 - г . соёлын нэгдэл
6. Аль нь соёлын тухай ойлголт биш вэ? 2оноо
 - а. Хүмүүсийн бүтээсэн бүхэнд мэдлэг ур ухаан, туршлага, итгэл үнэмшил, аж төрөх ёс нь хуримтлагдан шингэж үлддэг.
 - б. хүн байгалийн юмс үзэгдэлд ч тодорхой утга шингээн , бэлгэдэн уул овоо тахих, байгаль орчинтой холбоотой хорио цээрийн ёс гэх мэт бэлгэдэл , шүлтлэг хийсээр ирсэн
 - в. Нийгэм нэгдэлтэй тогтвортой оршин байхын тулд хэм хэмжээ, дэг журмыг сахих шаардлагатай байдаг
 - г.хүмүүсийн өдөр тутмын хэрэглээнд юуг зөв, зохистой гэж үзэх талаарх үнэлэмж, хэм хэмжээг илтгэдэг ба хүмүүсийн дунд сэтгэлгээний соёл, бие бялдын соёл, харилцааны соёл, хотын соёл, экологийн соёл гэх мэт ойлголтууд байдаг
7. Судлаачид соёлын үндэс суурь, анхдагч хэв маяг гэж мэдлэг ийн аль төрлийг үздэг вэ? 2оноо
 - а. Шашин
 - б . домог
 - в. философи
 - г. шинжлэх ухаан
 - д.Урлаг

8. “Байгалиас заяасан жам ёсны буюу заяагдмал” эрхийн сургаалийг үндэслэгч. 1оноо

- а. Эртний Грекийн Софистууд б. Мартин Лютер Кинг
в. Аугаа Сириус г. Элеанор Рузвельт

9. Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. 1оноо

- а. Үндсэн хууль б. Зөрчлийн тухай хууль
в. Эрүүгийн хууль г. Хүний эрхийн түгээмэл тунхаглал

10. Сахилгын зөрчил гаргаснаас хойш хэдийн хугацаанд шийтгэл ноогдуулах вэ? 1оноо

- а. 6 сарын дотор б. 3 сарын дотор в. 10 сарын дотор г. нэг жилийн дотор

11. Аль нь хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл биш вэ? 2оноо

- а. Аж ахуйн нэгж болон түүний салбар нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, ажилтны тоог цөөрүүлсэн
б. мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон
в. ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүсээгүй бол
г. ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсвэл хөдөлмөрийн харилцааг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд шууд заасан ноцтой зөрчил гаргасан

12. Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг ямар нөхцөлд олгодог вэ? 2оноо

- а. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 6 сар, түүний сүүлийн 3 сард тасралтгүй төлсөн нөхцөлд олгоно.
б. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийн 12 сар, түүний сүүлийн 6 сард тасралтгүй төлсөн нөхцөлд олгоно.
в. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийн 12 сар, түүний сүүлийн 3 сард тасралтгүй төлсөн нөхцөлд олгоно.
г. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийн 24 сар, түүний сүүлийн 6 сард тасралтгүй төлсөн нөхцөлд олгоно.

13. Манай орон гадаадын хэрэглэгчдэд бараагаа худалдаж орлого олохыг юу гэх вэ? 1оноо

- а. цэвэр экспорт б. экспортын орлого в. импортын орлого г. гадаад худалдаа

14. Улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнийн дүнг гэнэ. 1оноо

- а.ҮЦБ б . ДНБ в . ҮНБ г. 1 хүнд ногдох ДНБ

15. Дотоод болон хилийн чанад дахь Монголын хөрөнгө оруулалттай ААН-үүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөгийг хэрхэн нэрлэх вэ? 2 оноо

- а. ДНБ б . ҮНБ в . ҮЦБ г . Нэрлэсэн ДНБ

16. Үйлвэрлэлийн хүчин зүйлсээр ДНБ-г тодорхойлох аргыг..... тооцох гэнэ. **2оноо**

- а. Зардлаар б. Орлогоор

17. Бондын бусад энгийн болон банкны зээлүүдээс давуу талыг дурьдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? 2оноо

- а. Бага хүү төлдөг

б. Хугацааны хувьд уян хатан

в. Хүссэн хэмжээгээрээ хөрөнгө оруулалт татах боломжтой

г. Жил бүр хүү төлөхгүй байж болно

18. Ардчиллын үнэт зүйлсийг судлан цэгцэлсэн судлаач хэн бэ? 1 оноо

а. А. Линкольн б. Р.Даль в. Н Макиавелли г.Д .Истон

19.Олон түмэн өөрөө өөрийгөө удирдах хэлбэр. Эртний Грект иргэн бүрийг төрийг удирдах хэрэгт оролцуулдаг хэлбэр аль нь вэ? 1 оноо

а. шууд ардчилал б. төлөөллийн ардчилал в. төрийн ардчилал г. Ардчилал

20. Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, хүний хөгжлийг хангах орчныг бүрдүүлэх, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, ажилгүйдэл ядуурлыг бууруулахад чиглэгддэг үйл ажиллагааг... гэнэ.

а. Төрийн үйл ажиллагаа б. УИХ-ын үйл ажиллагаа

в. Засгийн газрын үйл ажиллагаа г. Төрийн үйлчилгээ

21. Монгол улсын засгийн газар бол төрийн.....байгууллага мөн. 2 оноо

а. хууль тогтоох б. гүйцэтгэх в. шүүх д. Хянах

22. Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадад бодлого, үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны салбарыггэнэ.

1 оноо

а. олон улсын хамтын ажиллагаа б. гадаад харилцаа

в. олон улсын харилцааны оролцогчид г. олон улсын харилцаа

23. Өөрийн аюулгүй байдлыг төдийгүй хөрш, холбоотон улсууд, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай олон улсын харилцааны “улс” оролцогчийг юу гэж нэрлэдэг вэ? 2 оноо

а. Их гүрэн б. Дунд улс в. Бага улс г. том улс

24. Мөнхийн дайсан гэж байдаггүй, мөнхийн хөрш гэж байдаг” ХХ зууныг шилдэг улс төрч хэн хэлсэн бэ? **2 оноо**

а. В.Черчилл б. М. Лютер в. Н.Мандела г. Р. Ганди

2-р хэсэг

2.1 3 оноо

1	Нийгмийн нэгдэл нягтралыг хангах дээд ариун нандин зүйлд итгэх	А	Гэр бүл
2	Хэрэгцээт бараа үйлчилгээгээр хангах	Б	Шашин, боловсрол
3	Нийгмийн шинэ гишүүнийг төрүүлэх	В	Эдийн засаг

А. 1а 2б 3в В. 1б 2а 3в С. 1в 2б 3а Д. 1б 2в 3а

2.2 Дараах нийгмийн зүтгэлтнүүдийг хэлсэн алдарт үгүүдийг зөв харгалзуулаарай.

3 оноо

1	“Нэг хүүхэд нэг багш нэг үзэг нэг ном дэлхийг өөрчилнө”	А	Элеанор Рузвельт
2	“Надад мөрөөдөл бий”	Б	Малала Юсуфзай
3	“Хүний эрх энгийн зүйлээс эхэлдэг”.	В	Мартин Лютер Кинг

А. 1а 2б 3в В. 1б 2а 3в С. 1б 2в 3а

2.3 Эдийн засгийн өсөлтийн талаарх дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу

3 оноо

1	Бодит ДНБ-ний өсөлт	А	Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн эцсийн бараа үйлчилгээний зах зээлийн үнийн дүн хэлнэ.
2	Нэг хүнд ноогдох ДНБ-ний өсөлт	Б	Эдийн засгийн өсөлт болон иргэдийн амьжиргааны түвшинг харьцуулж
3	ДНБ	В	Тухайн жилийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт буюу инфляцийн түвшинд харьцуулж тодорхойлно.

А.1б2в3А В.1Б2А3в С.1в2А3б D.1А2в3б

2.4 Өгөгдлийг зөв харгалзуулаарай.

3 оноо

1	Хууль тогтоох эрх мэдэл	А	Засгийн газар
2	Гүйцэтгэх эрх мэдэл	Б	Шүүх
3	Шүүх эрх мэдэл	В	УИХ

А. 1б 2в 3А В. 1в 2А 3б С. 1А 2в 3б

2.5 Өгөгдлийг зөв харгалзуулаарай.

3 оноо

1	Их гүрэн	А	Олон улсын харилцаанд нөлөө багатай ч өөрийн тусгаар тогтнол, гасар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэрэгсэлтэй байдаг.
2	Дунд улс	Б	Өөрийн аюулгүй байдлыг төдийгүй хөрө, холбоотон улсууд, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай байдаг.
3	Бага улс	В	Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрө улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд байдаг.

А.1Б2В3А В.1В2А3С С.1С2А3В D.1А2С3В

Хувилбар-4 Хариулт

№	Зөв хариулт	Оноо
1	Б	1
2	В	2
3	А	2
4	В	1
5	В	1
6	В	2
7	Б	2
8	А	1
9	Г	1
10	А	1
11	В	2
12	Б	2
13	А	1
14	Б	1
15	Б	2
16	Б	2
17	А	2
18	Б	1
19	А	1
20	Г	2
21	Б	2
22	Г	1
23	Б	2
24	А	2
25	2.1 D	3
26	2.2 C	3
27	2.4 А	3
28	2.5 В	3
29	2.6 А	3
	Нийт	52

БАТЛАВ

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

Г.АНХЖАРГАЛ

Анги дэвших шалгалт “Нийгэм” Х анги / сонгох шалгалт/

Хувилбар Б

1. “Дэлхий бол бүх орчлон ертөнцийн төвд хөдөлгөөнгүй оршдог” гэсэн өмнөх үеийн тайлбарт хатуу цохилт өгч Буд, Ангараг, Сугар гарагууд нь дэлхийг бус нарыг тойрон эргэдэг гэсэн дүгнэлтийг хэн гаргасан бэ? 1оноо
а. Н. Коперник б . Спиц в . М.Калмижн г . М.Вебер
2. “ Нийгмийн бодит байдлыг объективоор судлах боломжгүй ч далд оршин буй жинхэнэ бодит байдлыг илрүүлэхийн тулд зонхилох тайлбарт захирагдалгүйгээр судлан, бүтээгдсэн мэдлэгт дулдуйдан нийгмийг өөрчлөх боломжтой” гэдэг нь нийгмийг судлах \ социологийн \ аль онол вэ? 2оноо
а. Бүтэц чиг үүргийн онол б. Марксизм \ шүүмжлэлт онол
в. бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн онол г. эдийн засгийн онол
3. Тухайн байр суурь бүхий хүн юуг хийх нь зөвшөөрөгдөж байгааг ... гэнэ. 2оноо
а. Эрх б . Үүрэг в. байр суурь г . Хэм хэмжээ
4. “ Нийгмийн хөгжлийг тодорхойлогч гол хэмжүүр нь соёл мөн” гэсэн ойлголтыг аль нь тодорхойлсон бэ? 1оноо
а. Монгол улс б . НҮБ в . ЮНЕСКО г . Дэлхийн Зөн ОУБ
5. ” Монгол хэлний тухай “ хуулинд монгол хэл, бичиг үсгээ хамгаалах, хөгжүүлэх талаар идэвхи санаачлага гаргасан иргэн, хуулийн этгээдэд 4 жил тутамд ямар шагнал олгоно гэж заасан бэ? 1 оноо
а. Ерөнхийлөгчийн нэрэмжит б. ерөнхий сайдын нэрэмжит в. эх хэлний эзэн медаль
6. Монгол үндэстний соёлын нийтлэг шинжүүдээс аль нь биш вэ? 2оноо
а. Монгол орон бол эртний соёлт орон
б. Монгол улс дэлхийн хэд хэдэн соёлын хэв маягаас Дорнын соёлын хүрээнд хамаарна
в. Манай орон бол Буддын соёлт орон
г. Монгол орон бол суурьшмал соёл иргэншилтэй орон
7. “ Монголын түүх соёл бол үндэсний аюулгүй байдлын дархлаа мөн” аль хуулийн заалт вэ? 2оноо
а. Соёлын тухай хууль б. Үндсэн хууль в. үндэсний аюулгүй байдлын тухай хууль
8. “ Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх нь иргэний үндсэн үүрэг болохыг заасан.
а. Үндсэн хууль б. Зөрчлийн тухай хууль
в. Эрүүгийн хууль г. Хүний эрхийн түгээмэл тунхаглал

9. “ Эрх чөлөөний баримт бичиг буюу “ magna charta” нь аль улсын эрх чөлөөний тулгын чулуу гэгддэг вэ? 1оноо

- а. Грек б. Ром в. Англи г. НҮБ

10. Ажил шалтгаангүйгээр таслах, ажлаа зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас зохих этгээдээс гомдол гаргах, зөрчил нь шалгалтаар тогтоогдох, ажлын байранд согтуурах зэрэг тохиолдолд авах арга хэмжээг гэнэ. 1оноо

- а.Сахилгын сануулга б . сахилгын зөрчил в.зөрчил г. Торгох

11. Иргэд өндөр наслах, эмнэлэгээр эмчлүүлэх, өвдөх, тахир дутуу болох, ажилгүй болох зэрэг тохиолдолд нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн туслалцаа авах, түүнийг дуусгавар болгохтой холбогдон үүсч буй харилцаа аль нь вэ? 2 оноо

- а. иргэний рэх зүйн харилцаа б. захиргааны эрх зүйн харилцаа
в. нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаа г. хөдөлмөрийн эрх зүйн харилцаа

12. Ажилгүйдлийн тэтгэмжийг ямар нөхцөлд олгодог вэ? 2оноо

- а. ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
б. ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо 18 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
в. ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 5 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд
г. ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоосоо 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд

13. Инфляци, ажилгүйдэл,санхүүгийн зах зээл, ҮНБ,ДНБ зэрэг үзүүлэлтүүд нь макро эдийн засгийн асуудлууд юм. 1оноо

- а. тийм б. Үгүй

14. Эдийн засгийн салбар дахь хуулиас гадуур болон нарийн үнэлж чаддаггүй, заримыг ерөөс үнэлэх боломжгүй үйл ажиллагааг юу гэж нэрлэдэг вэ? 1 оноо

- а. хууль бус ажиллагаа б. сүүдрийн эдийн засаг
в. зах зээлээс гадуурх үйл ажиллагаа г. татвараас зугтсан үйл ажиллагаа

15. “ үлээх”, “хөөрөгдөх” гэсэн утгатай латин гаралтай үг бөгөөд эдийн засагт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ерөнхийдөө өсөж хүн амын худалдан авах чадвар буурах үзэгдэл аль нь вэ? 2оноо

- а. индекс б. инфляци в.брокер г. Дилер

16. .Талх үйлдвэрлэхэд ордог үр тариа, гурил нь ДНБ-г тооцоход оруулах уу?**2оноо**

- а. Тийм б. Үгүй

17. Төрийн албан хаагчдад зориулан бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах, сургууль, эмнэлэг зэргийг барихад гаргасан зардал нь дараах зардлын төрлүүдийн алинд нь хамаарах вэ? 2оноо

- а. Эрх гэрийн хэрэглээний зардал б. ААН-ийн хөрөнгө оруулалтын зардал
в. Төрийн зардал г. Гадаад хэрэглэгдийн зардал

18. Монголын Ардчилсан Холбооны анхны цуглаан хэзээ болсон бэ?

- а. 1989.12.10 б. 1992.01.13 в. 1994.01.13 г. 1995.11.26

19. Дэлхийн улс орнуудын авилагын индексийг судалж „дэлхийн нийтэд мэдээллэдэг байгууллага аль нь вэ? 1оноо

- А.Фрийдом хаус Б.Транспаренси интернэйшл В.Эмнэсти интернэйшл
Г.Соросын сан

20. Төрийн үйлчилгээг ил тод, чирэгдэлгүй, шуурхай , хүртээмжтэй хүргэхэд чиглэгдсэн төрийн үйлчилгээний шинэ хэлбэрүүдийг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? **2оноо**

- а. “Иргэдийг хүлээн авах төв” б. “ Нэг цонхны үйлчилгээ”
в. ТҮЦ машин г. “Олон нийттэй харилцах төв”

21. Аливаа төрд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн 3 эрх мэдэл оршдог. Эдгээр нь нэг этгээдэд нэгтгэгдвэл эрх чөлөө хэрэгжихгүй гэж хэн үзсэн бэ? **2оноо**

- а. Ш. Монтъеско б. Ж. Локк в. Д. Истон г. В. Черчилль

22. Олон улсын эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрөх хэлбэр аль нь вэ? **1оноо**

- а. де-факто б. де-юре

23. Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай гөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй олон улсын харилцааны “улс” оролцогчийг юу гэж нэрлэдэг вэ? **2оноо**

- а. Их гүрэн б. Дунд улс в. Бага улс г. том улс

24. . Монгол улс хоёр том хөрштэйгөө ... харилцах бодлого баримталдаг. **2оноо**

а.

соёлтой б. сонирхолтой в. тэнцвэртэй г. улс төрийн хүрээнд

2-р хэсэг

2.1 Зөв харгалзуулаарай

1	Нийгмийн нэгдэл нягтралыг хангах дээд ариун нандин зүйлд итгэх	А	Гэр бүл
2	Хэрэгцээт бараа үйлчилгээгээр хангах	Б	Шашин, боловсрол
3	Нийгмийн шинэ гишүүнийг төрүүлэх	В	Эдийн засаг

- A. 1а 2б 3в В. 1б 2а 3в С. 1в 2б 3а D. 1б 2в 3а

2.2 зөв харгалзуулаарай.

- 1Эрх зүйн бүрэн чадамж А 14-18 насны этгээд
2Эрх зүйн зарим чадамж Б 7 хүртэлх насны хүүхэд болон сэтгэцийн өвтэй хүн
3Эрх зүйн бүрэн бус В 18 наснаас дээш чадамж
4Эрх зүйн чадамжгүй Г 7-14 насны этгээд

А. 1Г 2Б 3А 4В В.1В 2Г 3А 4Б С. 1В 2Б 3Г 4А D. 1Б 2Г 3А 4В

2.3 Зөв харгалзуулаарай.

1	Хууль тогтоох эрх мэдэл	А	Засгийн газар
2	Гүйцэтгэх эрх мэдэл	Б	Шүүх
3	Шүүх эрх мэдэл	В	УИХ

А. 1А 2Б 3в В.1в 2А 3б С. 1б 2А3в D. 1А2б3в

2.4 Зөв харгалзуулаарай

- 1 Хэл А Соёл бол хүний амьдрах арга ухаан,
хуримтлуулсан туршлага болж
байдаг гэдэг утгаараа..... мөн
- 2 Мэдлэг Б Соёл бол сэтгэлгээний илэрхийлэл,
мэдээллийг бүтээгч, хадгалагч, дамжуулагч
арга хэрэгсэл болж байдаг утгаараа... мөн
- 3.үнэлэмж В Соёл бол юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, бас
юуг буруу зохисгүй гэж үзэх талаар нийтэд
хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанар болж
байдаг утгаараа... мөн

А.1А2В3Б В.1А2Б3В С.1Б2А3В D.1Б2В3А

2.5 Зөв харгалзуулаарай.

1	Олон тулгуурт байх	А	Энэ зарчим нь үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйлчилнэ.
2	Тэнцвэртэй байх	Б	Энэ зарчим бол стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ шат дарааллыг эрхэмлэсэн, Монгол улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэнэ
3	Үндэсний эрх ашигт нийцсэн байх	В	Энэ зарчим бол нэг талаас Монгол улсын үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс аль болох олон улс оронтой хамтран ажиллах, нөгөө талаас гадаад харилцааг аль болох олон хэлбэрээр явуулахад оршино

А.1А2б3в В.1в2А3б С.1б2в3А D.1в2б3А

А.1С2В3А В.1В2А3С С.1С2А3В D.1А2С3В

Хувилбар-Б Хариулт

№	Зөв хариулт	Оноо
1.	А	1
2.	Б	2
3.	А	2
4.	В	1
5.	А	1
6.	Г	2
7.	В	2
8.	А	1
9.	В	1
10.	Б	1
11.	В	2
12.	Г	2
13.	А	1
14.	Б	1
15.	Б	2
16.	А	2
17.	В	2
18.	А	1
19.	Б	1
20.	А	2
21.	А	2
22.	Б	1
23.	Б	2
24.	В	2
25.	2.1 D	3
26.	2.2 В	3
27.	2.3 В	3
28.	2.4 С	3
29.	2.5 D	3
30.	Нийт	52